



НИЙСЛЭЛИЙН
СТАТИСТИКИЙН
ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ



2021
06 САР

СТАТИСТИКИЙН
ТАНИЛЦУУЛГА

 www.ubstat.mn

 www.facebook.com/ubstat

 www.1212.mn



АГУУЛГА

Хуудасны
дугаар



НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,
2017-2021 ОН

1



НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,
ДҮҮРГЭЭР

2



НИЙГМИЙН ДААТГАЛ

4



ЭРҮҮЛ МЭНД

7



ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

12



ГЭМТ ХЭРЭГ

18



ТӨСӨВ

22



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

26



АЖ ҮЙЛДВЭР

36



МАЛ АЖ АХУЙ

42



ХОТЫН НИЙТИЙН АЖ АХУЙ

45

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2021 оны VI сарын танилцуулга

Хүснэгт 1. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний хагас жилд

Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2021
Шинээр төрсөн хүүхэд		хүн	↓ 18 309 ^{8.5}	↑ 20 042 ^{9.5}	↑ 20 239 ^{1.0}	↓ 19 727 ^{2.5}	↓ 18 555 ^{5.9}
Халдварт өвчнөөр өвчлөгчид		хүн	↓ 16 125 ^{42.7}	↑ 17 989 ^{11.6}	↓ 12 463 ^{30.7}	↓ 8 437 ^{32.3}	↑ 93 154 ^{11.0**}
Бүртгэгдсэн гэмт хэрэг		тоо	↓ 8 289 ^{17.5}	↑ 14 578 ^{75.9}	↓ 11 698 ^{19.8}	↓ 9 064 ^{22.5}	↓ 6 715 ^{25.9}
Хэрэглээний үнийн индекс, (сарын өөрчлөлт)		хувь	↓ 0.7 ^{0.2}	↑ 0.7 ^{1.4}	↑ 1.4 ^{0.7}	↓ 0.4 ^{1.0}	↑ 0.9 ^{0.5}
Гадаад валютын нэрлэсэн ханш (сарын дундаж)	Доллар (АНУ)	төгрөг	↑ 2 368 ^{20.5}	↑ 2 432 ^{2.7}	↑ 2 654 ^{9.1}	↑ 2 816 ^{6.1}	↑ 2 849 ^{1.2}
	Юань (БНХАУ)	төгрөг	↑ 348 ^{16.8}	↑ 376 ^{8.0}	↑ 385 ^{2.4}	↑ 398 ^{3.4}	↑ 443 ^{11.3}
	Рубль (ОХУ)	төгрөг	↑ 41 ^{36.7}	↓ 39 ^{4.9}	↑ 41 ^{5.1}	41 ^{0.0}	↓ 39 ^{4.9}
Нийслэлийн төсвийн орлого		тэрбум төгрөг	↓ 322.0 ^{25.6}	↑ 408.9 ^{27.0}	↑ 425.2 ^{4.0}	↓ 413.9 ^{2.7}	↑ 536.0 ^{29.5}
Нийслэлийн төсвийн зарлага		тэрбум төгрөг	↓ 430.5 ^{10.7}	↑ 543.9 ^{26.3}	↑ 567.5 ^{4.3}	↑ 618.4 ^{9.0}	↓ 565.9 ^{8.5}
Агаарын дундаж температур		°C	19.3	17.9	17.4	17.0	14.8

Тайлбар: өмнөх онтой харьцуулсан


 Эерэг хандлага, өөрчлөлт

 Сөрөг хандлага, өөрчлөлт

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2021 оны VI сарын танилцуулга

Хүснэгт 2. Нийслэлийн эдийн засаг, нийгмийн үзүүлэлтүүд, дүүргээр

Үзүүлэлт	Хэмжих Нэгж	2020 I-VI					2021 I-VI				
		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага		Хотын дундаж	Хамгийн өндөр		Хамгийн бага	
Хүн амын нягтрал /нэг кв км-т ногдох хүн/	Тоо	315	Баянгол	7 710	Налайх	55	321	Баянгол	7 914	Налайх	57
			Чингэлтэй	1 707	Багануур	46		Чингэлтэй	1 706	Багануур	47
			Сүхбаатар	703	Багахангай	30		Сүхбаатар	698	Багахангай	32
Нялхсын нас баралт /амьд төрсөн 1000 хүүхдэд/	0\00*	11	Сонгинохайрхан	13	Налайх	6	10	Налайх	25	Хан-Уул	7
			Чингэлтэй	12	Сүхбаатар	4		Багануур	13	Баянзүрх	6
			Баянгол	10	Багахангай	-		Сонгинохайрхан	13	Багахангай	-
10 000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчлөгсөд	0\000	50	Сонгинохайрхан	55	Сүхбаатар	35	326	Хан-Уул	662	Налайх	437
			Багануур	54	Хан-Уул	31		Баянзүрх	618	Багануур	244
			Баянзүрх	53	Багахангай	12		Баянгол	605	Багахангай	218
Төсвийн орлого, зарлагын харьцаа зарлага=100	тоо	71	Сүхбаатар	54	Багануур	9	95	Чингэлтэй	122	Багануур	14
			Чингэлтэй	53	Налайх	9		Хан-Уул	67	Налайх	12
			Хан-Уул	38	Багахангай	7		Сүхбаатар	57	Багахангай	9
16-аас дээш насны 10 000 хүнд ногдох Гэмт хэрэг	тоо	81	Сүхбаатар	155	Багахангай	61	61	Сүхбаатар	96	Налайх	43
			Баянгол	106	Налайх	54		Хан-Уул	74	Багахангай	40
			Баянзүрх	101	Багануур	43		Баянзүрх	71	Багануур	35

Тайлбар: * промилль ** продицимил

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V ... г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-IV, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав).

II. Дараах тэмдэглэгээг ашиглав.

- гүйцэтгэл байхгүй
- * урьдчилсан гүйцэтгэл
- ** дахин

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ


мянга	=1000
сая	=10 ⁶
тэрбум	=10 ⁹
их наяд	=10 ¹²
мян	мянга
%	хувь
мм	миллиметр
см	сантиметр
дм	дециметр
м	метр
км	километр
м ²	метр квадрат
дм ²	дециметр квадрат
км ²	километр квадрат
м ³	метр куб
га	гектар
мл	миллилитр
л	литр
г	грамм
кг	килограмм
цн	центнер
т	тонн
Вт	ватт
кВт.ц	киловатт цаг
кал	калори
ккал	килокалори
Гкал	гигакалори(=10 ⁹ калори)
с	секунд
мин	минут
мкг/м ³	микрограмм метр куб
м/с	метр секунд
ш	ширхэг
х.д.х	хэвлэлийн даралтат хуудас



НИЙГМИЙН ДААТГАЛ (2021 оны эхний хагас жилд)

ᠨᠢᠶᠭᠮᠡᠨ ᠳᠠᠭᠲᠠᠭᠠᠯ


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, тэрбум төгрөг




* ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

→ НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД


Албан журмаар даатгуулагчид



Сайн дураар даатгуулагчид



→ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИД ХАМРАГДАГЧИД



НИЙГМИЙН ДААТГАЛ

Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нийт иргэдийн 438.9 мянга (72.1%) нь аж ахуйн нэгж байгууллагын, 111.1 мянга (18.2%) нь төсөвт байгууллагын, 59.0 мянга (9.7%) нь сайн дурын даатгуулагчид байна. Даатгуулагчид өмнөх оны мөн үеэс 8.2 мянган (1.4%) даатгуулагчаар өссөн байна.

Нийслэлийн нийгмийн даатгалын газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2021 оны эхний хагас жилд 614.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 151.4 (7.6%) тэрбум төгрөгөөр өссөн, харин зарлага 833.9 тэрбум төгрөг болж 179.3 (37.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

2021 оны эхний хагас жилд нийслэлийн нийгмийн даатгалын салбарын үйлчилгээнд 31.5 мянган байгууллага, 608.9 мянган иргэн хамрагдаж, 833.9 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын сангуудаас зарлагдсан байна.


2021 оны эхний хагас жилд нийгмийн даатгалын сангийн нийт орлого 614.4 тэрбум төгрөг болж төлөвлөснөөс 43.6 тэрбум төгрөгөөр (7.6%) илүү бүрдсэн байна.

Хүснэгт 3. Нийслэлийн нийгмийн даатгалын сангийн орлого, дүүргээр, сая төгрөг

Дүүрэг	Орлого			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
Нийслэлийн дүн	570 776.7	614 362.8	107.6	43 586.1
Багануур	7 079.2	8 175.0	115.5	1 095.8
Багахангай	834.7	1 006.4	120.6	171.7
Баянгол	100 894.7	108 813.6	107.8	7 918.9
Баянзүрх	77 775.7	79 262.1	101.9	1 486.4
Налайх	5 106.6	4 937.6	96.7	- 169.0
Сонгинохайрхан	40 318.0	39 358.6	97.6	- 959.4
Сүхбаатар	122 296.4	136 334.8	111.5	14 038.4
Хан-Уул	93 789.7	102 012.8	108.8	8 223.1
Чингэлтэй	122 681.7	134 461.9	109.6	11 780.2

Нийгмийн даатгалын санд хуримтлуулсан нийт шимтгэлийн орлогын 91.2 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 4.0 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 4.1 хувь нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний (ҮОМШӨ) даатгалын санд, 0.7 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрчээ.

Зураг 1. Даатгалын сангийн зарлага, хувиар, VI сарын эцэст




2021 оны эхний хагас жилд нийслэлийн нийгмийн даатгалын сангаас даатгуулагч, иргэдэд 833.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг олгожээ.

Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагын 80.4 хувийг тэтгэврийн, 10.9 хувийг тэтгэмжийн, 4.0 хувийг ҮОМШӨ-ний, 4.7 хувийг ажилгүйдлийн даатгалын санд тус тус эзэлж байна.

Нийслэлийн нийгмийн даатгалын сангийн зарлага 2021 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27.4 хувиар өсөхөд тэтгэмжийн даатгалын сангийн зарлага хамгийн өндөр буюу 82.4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Зураг 2. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо



2021 оны эхний хагас жилд тэтгэврийн даатгалын сангаас 670.2 тэрбум төгрөгийн зарлага гаргаснаас 142.9 мянган (өндөр насны тэтгэвэр авагч) хүнд 396.9 тэрбум (59.2%) төгрөгийг, 24.1 мянган (хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр авагч) хүнд 46.4 тэрбум (6.9%) төгрөгийг, 7.1 мянган (тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч) хүнд 14.3 тэрбум (2.1%) төгрөгийг, 12.3 мянган (цэргийн тэтгэвэр авагч) хүнд 50.1 тэрбум (7.5%) төгрөгийг тус тус олгосон байна. Харин

162.3 тэрбум (24.2%) төгрөгийг бусад зардалд зарцуулжээ.

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвараа түр алдсан 26.2 мянган хүнд 6.0 тэрбум төгрөгийн, жирэмсэн болон амаржсан 19.9 мянган эхэд 39.8 тэрбум төгрөгийн, 3.4 мянган иргэний ар гэрт 3.4 тэрбум төгрөгийн оршуулгын тэтгэмж, 41.3 тэрбум төгрөгийг бусад зардалд тус тус олгосон байна.

Ойлголт, тодорхойлолт:

Нийгмийн даатгал нь иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан гэж ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч гэдэг нь хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр гэж даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдах, жирэмсний, амаржсаны чөлөө эдлэх, ажилгүй болох тохиолдолд даатгуулагч өөрт нь, даатгуулагч нас барах тохиолдолд гэр бүлд нь хууль заасан болзол, нөхцөлийн дагуу нийгмийн даатгалын сангаас тодорхой хугацаанд буюу нэг удаа олгох мөнгөн олговор байна.



ЭРҮҮЛ МЭНД (2021 оны эхний хагас жилд)

ᠡᠷᠦᠭᠦᠯᠡ ᠮᠡᠨᠳᠡ

Амаржсан эх



2020 VI 19 524

2021 VI 18 392

5.8%



Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид



2020 VI 8 437

2021 VI 93 154

11 дахин



Нялхсын эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд ногдох)

2020 VI

11.7

2021 VI

11.0

5 хүртэлх насны хүүхдийн
эндэгдлийн түвшин
(1000 амьд төрөлтөд ногдох)

2020 VI

12.9

2021 VI

12.7

ЭРҮҮЛ МЭНД


Нийслэлийн хэмжээнд 2021 оны эхний хагас жилд 18392 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс 1132 (5.8%) төрөлтөөр буурсан байна. Нийт төрөлтийн 11440 (62.2%) нь НЭМГ-ын харьяа эмнэлэгт, 6952 (37.8%) нь нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ЭМЯ-ны харьяа улс болон хувийн хэвшлийн эмнэлэгт амаржсан байна. Нийт амаржсан эхчүүдийн 0.3 хувийг гэрийн төрөлт эзэлж байна.

Хүснэгт 4. Төрсөн хүүхэд, эх, хүүхдийн эндэгдэл, жил бүрийн эхний хагас жилд

Үзүүлэлт	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	$\frac{2021}{2020}$ %
Амаржсан эхийн тоо	20 074	19 524	18 392	-5.8
Гэрийн төрөлт	68	67	49	-26.9
Хяналтгүй төрөлт	128	103	56	-45.6
Амьд төрсөн хүүхэд	20 239	19 727	18 555	-5.9
Эхийн эндэгдэл	6	7	20	2.9**
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	266	230	205	-10.9
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	13.1	11.6	11.0	-

2021 оны эхний хагас жилд 18555 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс 1172 (5.9%) хүүхдээр цөөн байна. Төрсөн нийт хүүхдийн 2652 (14.3%) нь бусад аймгийн харьяат эхчүүдээс мэндэлжээ.


Зураг 3. Амьд төрсөн хүүхэд, дүүргээр



Төрсөн нийт хүүхдийн 9569 (51.6%) нь эрэгтэй, 8986 (48.4%) нь эмэгтэй хүүхэд байна. Амьд төрсөн нийт хүүхдээс 2 ихэр 266, 3 ихэр 2 байна. Мөн 3.2 хувь нь 2500 граммаас бага жинтэй, 0.6 хувь нь төрөлхийн гажигтай төржээ.

Амьгүй төрөлтийн 105 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор буурсан байна. Амьгүй төрөлт Баянгол, Сүхбаатар дүүрэгт хотын дунджаас өндөр байна.


Зураг 4. Хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох), дүүргээр, эхний хагас жилд



2021 оны эхний хагас жилд бүртгэгдсэн нялхсын эндэгдлээс Сонгинохайрхан дүүрэгт 45 (21.9%) нь, Баянгол дүүрэгт 23 (11.2%) нь, Баянзүрх дүүрэгт 27 (13.2%) нь, Чингэлтэй дүүрэгт 16 (7.8%) нь, Хан-Уул дүүрэгт 15 (7.3%) нь, Сүхбаатар дүүрэгт 11 (5.4%) нь, Налайх дүүрэгт 12 (5.8%) нь, Багануур дүүрэгт 4 (2.0%) нь, бусад аймгийн харьяат 52 (25.4%), Багахангай дүүрэгт бүртгэгдээгүй байна.

Нийслэлд 2021 оны эхний хагас жилд 93154 хүн халдварт өвчнөөр өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 84717 (11.0 дахин их) хүнээр, 10000 хүн тутмаас халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 569.8 продицимилээр тус тус өссөн байна.

Зураг 5. Халдварт өвчнөөр өвчлөгчид, сараар



Халдварт өвчнөөр өвчлөгчдийг халдварт өвчний төрлөөр нь авч үзвэл амьсгалын замын цочмог халдварт өвчин 90766 (97.4%), бэлгийн замаар дамжих халдварт өвчин 2055 (2.2%), гэдэсний халдварт өвчин 30 (0.03%), зоонозын халдварт өвчин 8 (0.01%), бусад халдварт өвчин 295 (0.3%) байна.

2021 оны эхний хагас жилд **Коронавируст халдвар /COVID-19/-ын** 89960 тохиолдол бүртгэгдэж, нийт халдварт өвчний 96.6 хувийг эзэлж байна.

Хүснэгт 5. Нийслэлд гарсан халдварт өвчин, жил бүрийн эхний хагас жилд

Төрөл	Хэмжих нэгж	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	Өсөлт, бууралт 2021/2020	
					тоо/пункт	хувь
Халдварт өвчнөөр өвчилсөн хүн, бүгд	бодит тоо	12 463	8 437	93 154	84 717	11.0**
	10000 хүнд	87.1	57.9	627.7	569.8	
Үүнээс:						
Вируст гепатит	бодит тоо	110	111	25	-86	-77.5
	10000 хүнд	0.8	0.8	0.2	-0.6	
Цусан суулга	бодит тоо	1 846	794	24	-770	-97.0
	10000 хүнд	12.9	5.4	0.2	-5.2	
Салхин цэцэг	бодит тоо	4 132	1 031	30	-1 001	-97.1
	10000 хүнд	28.9	7.1	0.2	-6.9	
Гахай хавдар	бодит тоо	24	25	0	-25	-100
	10000 хүнд	0.2	0.2	0.0	-0.2	
Сальмонеллөз	бодит тоо	123	106	1	-105	-99.1
	10000 хүнд	0.9	0.7	0.01	-0.7	
Улаан эсэргэнэ	бодит тоо	410	95	3	-92	-96.8
	10000 хүнд	2.9	0.7	0.02	-0.7	
Хоолны хордлого	бодит тоо	553	71	0	-71	-100
	10000 хүнд	3.9	0.5	0.0	-0.5	
Ёлом	бодит тоо	60	37	1	-36	-97.3
	10000 хүнд	0.4	0.3	0.01	-0.3	
Бруцеллөз	бодит тоо	11	5	0	-5	-100
	10000 хүнд	0.1	0.03	0.0	0.0	
Гар хөл амны өвчин	бодит тоо	714	127	5	-122	-96.1
	10000 хүнд	5.0	0.9	0.03	-0.9	
Тэмбүү	бодит тоо	1 531	2 107	1 126	-981	-46.5
	10000 хүнд	10.7	14.5	7.6	-6.9	
Гонококкт халдвар	бодит тоо	840	1 230	499	-731	-59.4
	10000 хүнд	5.9	8.4	3.4	-5.0	
Трихомониаз	бодит тоо	789	1 057	425	-632	-59.8
	10000 хүнд	5.5	7.3	2.9	-4.4	
Сүрьеэ	бодит тоо	1 198	1 192	771	-421	-35.3
	10000 хүнд	8.4	8.2	5.2	-3.0	
ДОХ	бодит тоо	6	9	5	-4	-44.4
	10000 хүнд	0.04	0.06	0.03	0.03	
Өөр бүлэгт ангилсан өвчний шалтгаан болох коронавирус – (Covid 19)	бодит тоо	-	220	89 960	89 740	408.9**
	10000 хүнд		1.5	606.1	604.6	

Ойлголт, тодорхойлолт:

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Эхийн эндэгдлийн харьцаа (100000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд эндсэн эхийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байсан зэргийг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



ЦАГ УУР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ (2021 оны 6 дугаар сард)



Агаарын температур °C (Үнэмлэхүй их/бага)



32.2°C

Хамгийн дулаан хэм



-1.1°C

Хамгийн хүйтэн хэм

Гал түймрийн тоо



2021 VI 827^{28.7%↓}

2020 VI 1 160

Хүний үйл ажиллагаатай
холбоотой осол



1

Үйлдвэрийн осол



67

Бусад

Байгаль орчны зөрчил



97

ЦАГ УУР, АГААРЫН ЧАНАР, АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэлийн агаарын дундаж хэм 2021 оны 6 дугаар сард дунджаар 14.8°C байв. Энэ нь өмнөх оны мөн үеэс 2.2°C-аар, олон жилийн дундажтай харьцуулбал -1.8°C-аар хүйтэн байв. Энэ сарын хамгийн дулаан хэм 32.2°C, хамгийн хүйтэн хэм -1.1°C, хур тунадасны нийлбэр 83.5 миллиметр, салхины үнэмлэхүй их хурд 18 метр секунд хүрч, шороон болон цасан шуургатай 1 өдөр байна.

Хүснэгт 6. Агаарын бохирдолт, мг/м³, VI сард¹

Бодисын нэр		Стандарт хэмжээ	Хэмжилтийн тоо	Хамгийн их хэмжээ	Стандарт хэмжээнээс давсан тохиолдлын тоо	Агаарт байсан дундаж хэмжээ
Хүхэрлэг хий	SO ₂	0.050	369	0.045	-	0.011
Азотын давхар исэл	NO ₂	0.050	304	0.054	5	0.024
Тоосжилт	PM ₁₀	0.100	392	0.228	26	0.044
	PM _{2.5}	0.050	249	0.048	-	0.010
Нүүрстөрөгчийн дутуу исэл ²	CO	10.000	1 045	3.046	-	0.370
Озон	O ₃	0.100	600	0.096	-	0.044

Улаанбаатар хотын PM 2.5 тоосонцрын агууламж 2021 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.009 мг/м³ (45.6%)-ээр, өмнөх сараас 0.003 мг/м³ (25.7%)-оор бага, PM 10 тоосонцрын агууламж өмнөх оны мөн үеэс 0.032 мг/м³ (41.6%)-аар, өмнөх сараас 0.012 мг/м³ (21.2%)-ээр тус тус бага байна. Харин хүхэрлэг хий өмнөх оны мөн үеэс 0.005 мг/м³ (82.5%)-аар их байсан бол, өмнөх сараас 0.008 мг/м³ (45.5%)-аар бага, азотын давхар исэл өмнөх оны мөн үеэс 0.005 мг/м³ (17.0%)-оор бага, өмнөх сарын түвшинд байна.


Хүснэгт 7. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисын агууламж агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас давсан тохиолдлын тоо, станц, 2021 оны VI сард

Станцын байршил	Хүхэрлэг хий (SO ₂)	Азотын давхар исэл (NO ₂)	Нүүрс төрөгчийн дутуу исэл (CO)	Тоос (PM ₁₀)	Тоос (PM _{2.5})	Озон (O ₃)
Мишээл экспо	-	-	-	1	-	-
Баруун 4 зам	-	5	-	1	-	-
1-р хороолол	-	-	-	-	-	-
13-р хороолол	-	-	-	1	-	-
32-ын тойрог	-	-	-	15	-	-
Хархорин	-	-	-	6	-	-
Ургах наран хороолол	-	-	-	2	-	-
Хайлааст	-	-	-	-	-	-
248-р цэцэрлэг	-	-	-	-	-	-
Богд хааны ордон музей	-	-	-	-	-	-
Нисэх	-	-	-	-	-	-
Толгойт	-	-	-	-	-	-
Зурагт	-	-	-	-	-	-
Амгалан	-	-	-	-	-	-
Баянхошуу	-	-	-	-	-	-


¹ Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар

² 8 цагийн дундаж


Зураг 6. Улаанбаатар³ хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж, 13 станцын дундаж, мг/м³



Зураг 7. Улаанбаатар³ хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж, 12 станцын дундаж, мг/м³



Зураг 8. Улаанбаатар³ хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж, 15 станцын дундаж, мг/м³



Туул голын усны бохирдол:

Байгаль орчны хэмжил зүйн төв лабораторийн 2020 оны 6 дугаар сарын 23, 24-ний өдөр хийсэн хэмжилтээр Туул голын усны найрлага Туул-Налайх харуул цэгийн орчимд хэвийн, Туул-Сонгино доод харуул цэгийн орчимд эрдэс фосфор 14.8 дахин, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч 1.7 дахин хүлцэх хэмжээнээс давж Туул голын ус бохирдолтой хэвээр байна.

Хүснэгт 8. Нийслэлийн гадаргын усны найрлага, мг/м³, VI сард⁴

Үзүүлэлт		Стандарт хэмжээ	“Туул-Налайх” харуул цэг		“Туул-Сонгино доод” харуул цэг	
			Хэмжээ	Бодисын хэтрэлт	Хэмжээ	Бодисын хэтрэлт
Хүчилтөрөгч	O ₂	≥6	8.64	Хэвийн	6.72	хэвийн
Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч	BXX ₅	≤ 3	1.0	Хэвийн	5.1	1.7 дахин
Нитритийн нэгдэл	NO ₂	≤ 0.02	0.002	Хэвийн	0.002	хэвийн
Амоны азот	NH ₄	≤0.5	0.14	Хэвийн	0.18	хэвийн
Эрдэс фосфор	P	≤0.1	0.004	Хэвийн	1.48	14.8 дахин

³ Багануур, Багахангай, Налайх дүүрэгт агаарын бохирдол хэмжих харуул цэг байхгүй.

⁴ Эх үүсвэр: Байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори

"Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал" статистикийн 2021 оны VI сарын танилцуулга

Хүснэгт 9. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулагч бодисын хоногийн дундаж агууламж, мг/м³, VI сард

Агаарын бохирдлын үзүүлэлт		Мишээл- Экспо төв	Баруун дөрвөн зам	I хороолол	XIII хороолол	32-ын тойрог	Хархорин зах	Ургах наран хороолол	Хайлаас т	248-р цэцэрлэг	Богд хааны ордон музей	Нисэх	Толгойт	Зурагт	Амгалан	Баян- хошуу
Хүхэрлэг хий SO ₂	Дундаж	0.012	0.007	0.015	0.004	0.005	0.006	0.004	0.010	0.010	0.007	0.020	-	0.017	0.021	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь	0.036	0.015	0.038	0.011	0.015	0.015	0.021	0.017	0.019	0.017	0.036	-	0.033	0.045	-
		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	27	30	30	30	30	30	27	30	29	30	23	-	23	30	-
Азотын давхар исэл NO ₂	Дундаж	0.030	0.044	0.023	0.032	0.031	0.027	0.015	0.010	0.018	0.028	0.015	-	-	0.019	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь	0.044	0.054	0.035	0.046	0.041	0.041	0.024	0.015	0.029	0.043	0.030	-	-	0.042	-
		-	17.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	28	30	30	30	16	30	9	30	18	26	27	-	-	30	-
Нүүрс төрөгчийн дутуу исэл, CO**	Дундаж		0.514	0.509	0.152	0.425	0.363	0.304	0.513	-	0.240	0.238	0.394	0.457	0.330	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь		1.339	3.046	0.739	1.108	1.259	0.858	1.941	-	0.546	0.801	2.038	1.669	1.321	-
		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо		90	90	90	90	90	87	88	-	90	80	87	79	84	-
Тоос PM ₁₀	Дундаж	0.049	0.059	0.046	0.051	0.095	0.073	0.054	0.024	0.034	0.031	0.025	0.010	0.026	0.042	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь	0.130	0.104	0.084	0.125	0.228	0.140	0.151	0.054	0.075	0.078	0.065	0.027	0.047	0.084	-
		4.0	3.0	-	3.0	50.0	20.0	7.0	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	27	30	28	30	30	30	27	30	27	30	18	30	27	28	-
Тоос PM _{2.5}	Дундаж	-	0.014	0.01	-	-	-	-	0.010	0.024	0.003	0.006	0.005	0.008	0.011	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь	-	0.026	0.023	-	-	-	-	0.018	0.048	0.013	0.014	0.009	0.013	0.018	-
		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	30	30	-	-	-	-	30	26	30	18	30	27	28	-
Озон O ₃ **	Дундаж	-	-	-	0.030	0.027	-	0.039	-	-	-	0.057	0.043	0.058	0.054	-
	Хамгийн их XXX*-с давсан хувь	-	-	-	0.064	0.048	-	0.072	-	-	-	0.096	0.073	0.094	0.086	-
		-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжилтийн тоо	-	-	-	90	90	-	87	-	-	-	80	87	79	87	-

* Хүлцэх хэм хэмжээ,

**CO, O₃-ийн хэмжилтийг 8 цагийн дунджаар тооцсон

Байгаль орчны зөрчил:

Нийслэлийн хэмжээнд 2021 оны эхний хагас жилд байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчсөн 97 зөрчлийг илрүүлжээ. Илрүүлсэн нийт зөрчлийн 13.4 хувийг ан амьтны зөрчил, 44.3 хувийг газрын зөрчил, 16.3 хувийг геодези зураг зүй, кадастрын зөрчил, 12.2 хувийг газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхайн зөрчил, 3.1 хувийг усны зөрчил, 5.1 хувийг агаар, химийн хорт бодисын зөрчил, 5.1 хувийг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний зөрчил, 1.0 хувийг бусад зөрчил тус тус эзэлж байна. Илрүүлсэн нийт зөрчилд 240.4 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Хүснэгт 10. Байгаль орчны зөрчил, төрлөөр, 2021 оны эхний хагас жилд⁵

Илрүүлсэн зөрчил, төрлөөр	2020 I-VI			2021 I-VI		
	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)	Үзлэг шалгалт	Илрүүлсэн зөрчил	Торгууль (сая төгрөг)
Бүгд	284	284	263.7	98	97	240.4
Ой	1	1	0.3	-	-	-
Ан, амьтан	9	9	15.8	13	13	16.6
Газрын	111	111	133	43	43	98.5
Ус	-	-	-	3	2	87.8
Ургамал, хөрсний бохирдол	-	-	-	-	-	-
Агаар, химийн хорт бодис	6	6	11.1	5	5	12.3
Газрын хэвлий, ашигт малтмал, уул уурхай	37	37	47.0	12	12	11.8
Геодези зураг зүй, кадастр	72	72	12.1	16	16	5.1
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ	28	28	32.0	5	5	7.3
Бусад	1	1	12.4	1	1	1.0

АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ

Нийслэл хотын нутаг дэвсгэрт 2021 оны эхний хагас жилд 92 гамшиг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар буурсан байна. Нийт гамшигт хүчтэй салхи шуурга 1, аадар бороо, үер 1, хүний үйл ажиллагаатай холбоотой 90 осол бүртгэгдсэн байна. Хүний үйл ажиллагаатай холбоотой осолд үйлдвэрийн 1 осол, сум галт хэрэгслийн 1 осол, усны 19 осол, тэсрэх дэлбэрэх бодисын 2 осол, сум галт хэрэгслийн 1 осол, бусад төрлийн 67 осол бүртгэгджээ. Гамшгийн улмаас 23 хүн амь насаа алдаж, 98 хүнийг аварч, гамшгийн уршгийг арилгах ажилд нийт 3.3 сая төгрөг зарцуулжээ.

Хүснэгт 11. Гал түймрийн тоо, дүүргээр, жил бүрийн эхний хагас жилд


Дүүрэг	2016	2017	2018	2019	2020	2021	$\frac{2021}{2020}$ %
Нийслэлийн дүн	1 447	1 521	1 404	1 755	1 160	827	71.3
Багануур	24	20	16	26	17	16	94.1
Багахангай	4	2	3	5	4	3	75.0
Баянгол	224	218	229	207	145	106	73.1
Баянзүрх	372	343	367	430	259	201	77.6
Налайх	60	48	49	36	32	21	65.6
Сонгинохайрхан	291	339	301	450	298	192	64.4
Сүхбаатар	172	208	165	225	152	112	73.6
Хан-Уул	133	161	133	165	123	86	69.9
Чингэлтэй	167	182	141	211	130	90	69.2

Нийслэл хотод 2021 оны эхний хагас жилд ахуйн 827 гал түймэр гарч өмнөх оны мөн үеэс 28.7 хувиар буурав. 2021 оны эхний хагас жилд худал дуудлагын тоо 13 болж өмнөх оны мөн үеэс 4 дуудлагаар буюу 23.5 хувиар буурсан байна. Гал түймрийн улмаас 19 хүн (үүнээс, хүүхэд 6) амь насаа алдаж, 25 хүн түлэгдэж гэмтсэн байна.


⁵ НМХГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтэс

Гал түймрийн аюулаас 586 хүн, 277 байшин барилга, 43.2 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг аварсан байна. Гал түймрийг гарсан шалтгаанаар нь ангилбал цахилгаанаас 216, санамсаргүй байдлаас 541, санаатай үйлдлээр 2, шалтгаан тогтоогдоогүй 2, бусад шалтгаанаар 66 гал түймэр гарчээ.

Зураг 9. Гал түймэр, байршлаар



Зураг 10. Гал түймэр, шалтгаанаар



Гал түймэрт 468 гэр, орон сууц, 35 барилга байгууламж, тоног төхөөрөмж, 67 машин техник, малын 5 хашаа, саравч, бусад төрлийн 252 объект өртжээ. Гал түймэрт иргэний хувийн өмчийн 577, төрийн өмчийн 208, хувийн аж ахуйн нэгж, байгууллагын өмчийн 42 объект өртөж, нийт 1620.6 сая төгрөгийн хохирол учирсан байна.

Нийслэлийн Онцгой байдлын газраас 2021 оны эхний хагас жилд 70 барилгын зураг төсөл, мөн ашиглалтад хүлээн авч буй 182 барилгад хяналт тавьж ажиллажээ. Түүнчлэн 6398 айл өрх, 4572 объектод үзлэг шалгалт хийж, 12730 галын зөрчил илрүүлж, байгууллага, албан тушаалтан, иргэнд 922 заавал биелүүлэх албан шаардлага, 1337 мэдэгдэл хүргүүлж, 34.2 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



ГЭМТ ХЭРЭГ (2021 оны эхний хагас жилд)

ᠮᠤᠩᠭᠡᠨ
ᠬᠡᠮᠤᠲᠤ
ᠬᠡᠷᠡᠭ



Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг (дүүргээр)

2020 VI

9 064

2021 VI

6 715

26.0%↓



↓↑ Өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хувиар

Гэмт хэргийн улмаас



Хохирсон хүн

6 465



Гэмтсэн хүн

1 968



Нас барсан хүн


130

ГЭМТ ХЭРЭГ

2021 оны эхний хагас жилд 6715 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2349 (25.9%) хэргээр буурч, гэмт хэргийн илрүүлэлт 43.4 хувьтай байгаа нь 2.0 пунктээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 1968 хүн гэмтэж осолдон, 130 хүн нас барж, төр ард иргэдэд 74.8 тэрбум төгрөгийн хохирол учруулснаас 34.1 тэрбум (45.5%) төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Зураг 11. Бүртгэгдсэн гэмт хэрэг, сараар



Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 32.6 хувийг залилан, 29.1 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 16.2 хувийг хулгайн, 0.8 хувийг бусдыг амиа хорлоход хүргэх, 2.2 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг, 1.5 хувийг хүчин, 1.6 хувийг бусдын хөрөнгө ашиглах, 0.8 хувийг хүн амь, 1.5 хувийг дээрмийн, 13.8 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, төрлөөр, жил бүрийн эхний хагас жилд

Төрөл	Гэмт хэргийн тоо			Өсөлт, бууралт, 2021/2020	
	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	11 698	9 064	6 715	-2 349	-25.9
Хүний амь	63	56	56	0	0.0
Хүчин	139	96	99	3	3.1
Дээрэм	433	220	99	-121	-55.0
Хулгай	3 649	2 795	1 086	-1 709	-61.1
Залилан	2 575	2 135	2 187	52	2.4
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	2 715	2 288	1 952	-336	-14.7
Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журам зөрчих	367	199	151	-48	-24.1
Бусдыг амиа хорлоход хүргэх	107	75	51	-24	-32.0
Ашиглах	205	165	104	-61	-37.0
Танхайрах	13	6	3	-3	-50.0
Бусад	1 432	1 029	927	-102	-9.9

2021 оны эхний хагас жилд 26062 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 12601 (32.6%) хүнээр буурсан байна.

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2021 оны VI сарын танилцуулга

Хүснэгт 13. Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг, дүүргээр, жил бүрийн эхний хагас жилд

Дүүрэг	Бүртгэгдсэн нийт гэмт хэрэг			Өсөлт, бууралт 2021/2020	
	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	Тоо	Хувь
Нийслэлийн дүн	11 698	9 064	6 715	-2 349	-25.9
Багануур	104	84	70	-14	-16.7
Багахангай	10	15	12	-3	-20.0
Баянгол	1 984	1 582	1 126	-456	-28.8
Баянзүрх	3 098	2 443	1 724	-719	-29.4
Налайх	169	162	109	-53	-32.7
Сонгинохайрхан	1 838	1 342	1 121	-221	-16.5
Сүхбаатар	1 838	1 543	940	-603	-39.1
Хан-Уул	1 176	895	891	-4	-0.4
Чингэлтэй	1 481	998	722	-276	-27.7

2021 оны эхний хагас жилд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 6037 (89.9%) нь хөнгөн хэрэг, 678 (10.1%) нь хүнд хэрэг байна.⁶

Хүснэгт 14. Гэмт хэрэг бүртгэгдэх үед сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийн тоо, дүүргээр, 2021 оны эхний хагас жилд

Дүүрэг	Хэрэг бүртгэлтийн хэргийн тоо	Үүнээс:	Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь
		Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан хэрэг	
Нийслэлийн дүн	4 754	2 064	43.4
Багануур	34	17	50.0
Багахангай	3	-	0.0
Баянгол	799	409	51.2
Баянзүрх	1 298	545	42.0
Налайх	32	13	40.6
Сонгинохайрхан	769	372	48.4
Сүхбаатар	533	187	35.1
Хан-Уул	782	345	44.1
Чингэлтэй	504	176	34.9

Зураг 12. Гэмт хэргийн илрүүлэлт, 2021 оны эхний хагас жилд



⁶ Монгол Улсын Эрүүгийн тухай хууль шинэчлэгдэн батлагдаж, 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор гэмт хэргийг хөнгөн, хүнд гэж 2 ангилдаг болсон.

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2021 оны VI сарын танилцуулга

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн тоо 2021 оны эхний хагас жилд 4371 болж, өмнөх оны мөн үеэс 453 (9.4%) хүнээр буурсан байна.

Нийт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчийн 1001 (22.9%) нь согтуугаар, 507 (11.6%) нь гэмт хэргийг бүлэглэн үйлджээ. Сэжигтэн, яллагдагчийн 210 (4.8%) нь хүүхэд, 978 (22.4%) нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 15. Бүртгэгдсэн хулгайн гэмт хэрэг, дүүргээр, жил бүрийн эхний хагас жилд

Дүүрэг	Хулгайн гэмт хэргийн тоо, бүгд			Үүнээс: Хувийн өмчийн хулгайн гэмт хэргийн тоо		
	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI	2019 I-VI	2020 I-VI	2021 I-VI
Нийслэлийн дүн	3 649	2 795	1 086	3 262	2 463	899
Багануур	27	16	4	21	14	3
Багахангай	2	3	1	2	3	1
Баянгол	555	338	192	482	256	137
Баянзүрх	1 033	851	305	908	712	249
Налайх	51	36	7	50	32	6
Сонгинохайрхан	649	525	186	612	506	174
Сүхбаатар	556	466	156	497	416	129
Хан-Уул	286	286	128	248	270	116
Чингэлтэй	490	274	107	442	254	83

Ойлголт, тодорхойлолт:

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000- аар үржүүлж тооцно.


Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.


Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж




ТӨСӨВ (2021 оны эхний хагас жилд)



Төсвийн орлого, зарлагын бүтэц



■ Татварын орлого
■ Татварын бус орлого



■ Урсгал зардал
■ Хөрөнгийн зардал

НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВ

“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2021 оны VI сарын танилцуулга

Хүснэгт 17. Нийслэлийн төсвийн орлого, сая төгрөг


Үзүүлэлт	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	ТБ %	Зөрүү, сая төгрөг
Нийт орлого	573 698.5	536 005.6	- 6.6	- 37 692.8
1. Татварын орлого	524 020.7	493 611.7	- 5.8	- 30 408.9
Орлогын албан татвар	374 662.4	339 562.0	- 9.4	- 35 100.4
Хувь хүний орлогын албан татвар	402 662.4	357 251.8	- 11.3	- 45 410.6
Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын	292 500.0	237 735.4	- 18.7	- 54 764.6
Үйл ажиллагааны орлогын	21 000.8	19 465.8	- 7.3	- 1 535.0
Хөрөнгийн орлого	50 851.0	55 541.1	9.2	4 690.1
Хөрөнгө борлуулсны орлогын	6 105.7	22 445.4	267.6	16 339.7
Шууд бус орлого	32 204.9	22 064.1	- 31.5	- 10 140.8
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	- 28 000.0	- 17 689.8	- 36.8	10 310.2
Хөрөнгийн албан татвар	68 432.3	51 851.6	- 24.2	- 16 580.7
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	36 848.0	27 823.9	- 24.5	- 9 024.1
Бууны албан татвар	216.3	139.1	- 35.7	- 77.2
Малд ногдуулах албан татвар	18.0	-	-	- 18.0
Авто тээврийн ба өөрөө явагч хэрэгслийн	31 350.0	23 888.6	- 23.8	- 7 461.4
Бусад татвар, төлбөр, хураамж	80 926.0	102 198.1	26.3	21 272.1
Бусад нийтлэг төлбөр, хураамж	25 413.5	58 696.9	131.0	33 283.4
Газрын төлбөр	50 459.9	40 017.0	- 20.7	- 10 442.9
Байгалийн нөөц ашигласны төлбөр	1 912.6	1 397.1	- 27.0	- 515.5
Бусад татвар	3 140.0	2 087.1	- 33.5	- 1 052.9
2. Татварын бус орлого	49 677.8	42 393.9	- 14.7	- 7 283.9
Нийтлэг татварын бус орлого	49 677.8	42 308.8	- 14.8	- 7 369.0
Хувьцаа ногдол ашиг, Хүүгийн орлого	47.0	-	-	- 47.0
Төсөвт байгууллагын өөрийн орлого	6 282.3	3 064.2	- 51.2	- 3 218.1
Торгуулийн орлого	25 880.7	25 210.9	- 2.6	- 669.8
Түрээсийн орлого	983.0	904.2	- 8.0	- 78.8
Бусад нэр заагдаагүй орлого	16 484.8	13 129.5	- 20.4	- 3 355.2
Өмч хувьчлал	-	85.1	-	85.1

2021 оны эхний хагас жилд нийслэлийн төсвөөс нийслэл, дүүргийн байгууллагуудын төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын 56.6 хувийг (565.9 тэрбум төгрөг) санхүүжүүлжээ. Өөрөөр хэлбэл нийслэл, дүүргийн байгууллагууд батлагдсан төсвийнхөө 43.4 хувийг (434.3 тэрбум төгрөг) төлөвлөсөн хугацаандаа зарцуулаагүй байна.

Хүснэгт 18. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг

Дүүрэг	Орлогын дүн	Зарлага				Орлого, зарлагын зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү	
Нийслэлийн дүн	536 005.6	1 000 207.4	565 871.1	- 43.4	- 434 336.3	- 29 865.5
Багануур	1 483.8	12 476.3	10 751.8	- 13.8	- 1 724.5	- 9 268.0
Багахангай	288.5	3 840.6	3 332.5	- 13.2	- 508.1	- 3 044.0
Баянгол	17 299.2	59 459.7	48 937.4	- 17.7	- 10 522.3	- 31 638.2
Баянзүрх	28 228.4	88 453.3	71 994.2	- 18.6	- 16 459.1	- 43 765.8
Налайх	1 495.4	14 088.3	12 288.1	- 12.8	- 1 800.2	- 10 792.7
Сонгинохайрхан	12 045.9	76 938.7	63 135.2	- 17.9	- 13 803.5	- 51 089.3
Сүхбаатар	40 322.9	97 564.9	71 068.4	- 27.2	- 26 496.5	- 30 745.5
Хан-Уул	34 407.7	77 291.9	51 777.5	- 33.0	- 25 514.4	- 17 369.8
Чингэлтэй	60 961.6	60 480.7	50 071.0	- 17.2	- 10 409.7	10 890.6
Хотын шууд	339 472.2	509 613.0	182 515.0	- 64.2	- 327 098.0	156 957.0

Зураг 14. Нийслэлийн төсвийн зарлага, сая төгрөг



Ойлголт, тодорхойлолт:

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ.

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан, тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Урсгал зардал: Бараа, ажил, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (2021 оны 6 дугаар сард)

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

Ерөнхий индекс

7.1

Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ

14.1

Хүнсний бараа, согтууруулах бус ундаа

13.1

Тээвэр

6.9

Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ

6.6

Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш

6.1

Бусад бараа, үйлчилгээ

5.9

Гэр ахуйн тавилга, бараа

3.1

Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис

3.1

Хувцас, бөс бараа, гутал

1.6

Боловсролын үйлчилгээ

1.4

Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ

1.3

Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ

0.3


-15 -12 -9 -6 -3 0 3 6 9 12 15

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар өслөө.

2021 оны 6 дугаар сарын хэрэглээний үнийн индекс 2020 оны эцэстэй харьцуулахад 8.4 хувь, өмнөх сартай харьцуулахад 0.9 хувиар тус тус өссөн байна.

Зураг 15. Хэрэглээний үнийн индекс



Хэрэглээний үнийн индекс 2021 онд өмнөх оны эцэстэй харьцуулахад 8.4 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундаа бүлгийн үнэ 16.4 хувь, согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис бүлгийн үнэ 2.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш бүлгийн үнэ 22.5 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа бүлгийн үнэ 1.4 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ бүлгийн үнэ 4.8 хувь, тээвэр бүлгийн үнэ 3.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ бүлгийн үнэ 0.3 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 0.4 хувь, боловсролын үйлчилгээ бүлгийн үнэ 0.8 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ бүлгийн үнэ 12.7 хувь, бусад бараа, үйлчилгээ бүлгийн үнэ 2.5 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 19. Хэрэглээний үнийн индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	<u>2020-VI</u> 2019-VI	<u>2021-VI</u> 2020-VI	<u>2021-VI</u> 2020-XII	<u>2021-VI</u> 2021-V
Ерөнхий индекс	102.4	107.1	108.4	100.9
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	104.2	113.1	116.4	101.2
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	105.2	103.1	102.4	100.6
Хувцас, бөс бараа, гутал	104.6	101.6	98.9	100.2
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	103.5	106.1	122.5	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	102.9	103.1	101.4	100.6
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	103.1	106.6	104.8	101.4
Тээвэр	92.4	106.9	103.4	101.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.2	100.3	100.3	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	98.3	101.3	100.4	100.1
Боловсролын үйлчилгээ	107.0	101.4	100.8	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	108.7	114.1	112.7	104.3
Бусад бараа, үйлчилгээ	104.5	105.9	102.5	100.2


“Нийслэлийн эдийн засаг, нийгмийн байдал” статистикийн 2021 оны VI сарын танилцуулга

2021 оны 6 дугаар сард үнийн ажиглалт хийхээр хэрэглээний сагсанд сонгогдсон 344 нэрийн бараа, үйлчилгээний 24.1 хувийнх нь үнэ өсөж, 4.9 хувийнх нь үнэ буурч, 71.0 хувийн бараа үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад тогтвортой байв.


Хүснэгт 20. Улаанбаатар хотын хэрэглээний үнийн сарын индекс, /**зөрөг**, **сөрөг**/

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
